



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 439

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох  
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.6 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Сумын төвийн цахилгаан хангамжийн өргөтгөл, шинэчлэл (Увс аймаг, Өлгий сум)” төсөл арга хэмжээний барилга угсралтын ажлын хүрээнд бий болсон нийт 206,370,000.00 (хоёр зуун зургаан сая гурван зуун далан мянган) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, “Увс цахилгаан түгээх сүлжээ” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ц.Эрдэнэбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомж журмын дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2022 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН "УВС ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ"  
 ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ  
 ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Хүчин чадал		Балансын үнэ (төгрөгөөр)
			Хэмжих нэгж	Биет хэмжээ	
1	Увс аймгийн Өлгий сумын Хар УС АТП-70 цахилгаан хангамжийн өргөтгөл /Байршил-А/	2017	ком	1	92,904,430.00
2	Увс аймгийн Өлгий сумын Хар УС АТП-70 цахилгаан хангамжийн өргөтгөл /Байршил-Б/	2017	ком	1	113,465,570.00
					<b>206,370,000.00</b>
	<b>Нийт дүн</b>				<b>(хоёр зуун зургаан сая гурван зуун далан мянган төгрөг)</b>